# МАЛ, АМЬТНЫ ХАЛДВАРТ ӨВЧИН, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ





## МАЛ, АМЬТНЫ ХАЛДВАРТ ӨВЧИН ГЭЖ ЮУ ВЭ?







Бичил биетнээр үүсгэгддэг



Мал, амьтан ижил шинж тэмдэгтэй өвчилж, олноор гэнэт үхэж хорогдоно



Эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг

# ШҮЛХИЙ ӨВЧНИЙ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС ХАМТДАА СЭРГИЙЛЬЕ

## ИРГЭН ТА:

Танай үхэр, гахай, хонь, ямаа өвс, тэжээл, усанд дурамжхан болж номойрч зурагт үзүүлсэн ил шинж тэмдэг илэрвэл:

1. Нэн даруй малын эмчид дуудлага өгнө.
2. Шинж тэмдэгтэй малыг тусгаарлана.
3. Өөрийн малыг өөр айлын мал сүрэгтэй нийлүүлэхгүй байх арга хэмжээ авна.

## МАЛЫН ЭМЧ ТА:

Анхны үзлэгээр зурагт үзүүлсэн ил шинж тэмдэг илэрвэл:

1. Цусны дээж, эмгэгт материалын эдийн дээжийг зааврын дагуу авч лабораторид хүргүүлнэ.
2. Бүх малд үзлэг хийж ил шинж тэмдэгтэй малыг тусгаарлана.
3. Хязгаарлалтын дэглэм тогтоох арга хэмжээ авч ус, бэлчээр нэгтэй айлуудын малд нэг бүрчлэн үзлэг хийнэ.
4. Өвчний онош тогтоогдож шийдвэр гарах хүртэл тогтоосон хязгаарлалтын бүсээс гарахыг хориглоно.

## МЭ-ИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ТА:

1. Анхны шинж тэмдгийг үндэслэн хязгаарлалтын дэглэм тогтоох шийдвэр гаргуулна.
2. Хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоож хяналтандаа авч, эргүүл пост гаргана.

## ҮХЭРТ ИЛРЭХ ШИНЖ ТЭМДЭГ






## ГАХАЙД ИЛРЭХ ШИНЖ ТЭМДЭГ






## ХОНЬ, ЯМААНД ИЛРЭХ ШИНЖ ТЭМДЭГ






# ШҮЛХИЙ ӨВЧНИЙ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС ХАМТДАА СЭРГИЙЛЬЕ

## ШҮЛХИЙ ӨВЧНИЙ ХАЛДВАР АВСАН МАЛ, АМЬТНЫ МАХЫГ ХЭРХЭН БОЛОВСРУУЛАХ ВЭ.

**OIE-н зааврааc**

**Эрүүл мэндийн үзлэг хийнэ.**



**Үйлдвэрийг халдваргүйжүүлж бэлтгэнэ**



**Ариун цэврийн нядалгаанд оруулна.**



**Толгойн үзлэг хийнэ**






**Шүлхий өвчний халдвар авсан мал, амьтныг зааврын дагуу зөвхөн үйлдвэрт ариун цэврийн нядалгаанд оруулна.**



**Дотор эрхтэнд үзлэг хийнэ.**



**Гулуузанд үзлэг хийж бүх тунгалгийн зангилааг авсан байна. Махны pH 6-с доош байна.**




**Зөвхөн боловсруулалт хийж худалдаанд гарахыг зөвшөөрнө. Түүхий мах худалдаанд гаргахыг хориглоно.**



**Нядалгааны дараа үйлдвэрт зааврын дагуу халдваргүйтгэл хийнэ.**

# ШҮЛХИЙ ӨВЧНИЙ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС ХАМТДАА СЭРГИЙЛЬЕ

## ШҮЛХИЙ ӨВЧИН ТАНЬД ЯМАР ХОХИРОЛТОЙ ВЭ

Мал өвчлөх нь таны өрхийн санхүүд хохирол учирна



Эрүүл мал танд илүү их ашиг орлого өгнө

### Таны малд шүлхий өвчин оношлогдвол:

1. Таны мах, сүү болон бусад түүхий эд худалдаанд гарахад саадтай болно.
2. Түүхий эд, бүтээгдэхүүний үнэ унана.
3. Таны өрхий орлого буурна.
4. Малын гаралтай бүтээгдэхүүн экспортод хориг тавигдана.
5. Улсын эдийн засагт хохирол учирна.
6. Таньд болон танай гэр бүлд үзүүлэх эрүүл мэнд, боловсролын болон бусад халамжийн үйлчилгээний зардал буурна





### Таны мал эрүүл бол:

1. Таны малын ашиг шимийн гарц өндөр байна.
2. Бүтээгдэхүүний борлуулалтад саад үгүй байна.
3. Таны өрхий орлого нэмэгдэнэ.
4. Улсын эдийн засаг өсөж та хүртэх нийгмийн халамж нэмэгдэнэ

# ХОНЬ, ЯМААНЫ ЦЭЦЭГ ӨВЧНИЙ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС ХАМТДАА СЭРГИЙЛЬЕ

## ИРГЭН ТА:

Танай хонь, ямаа өндөр халуурч, арьс, салст бүрхүүлд цэврүүт гүвдрүү үүсэх, дотоод эрхтний үрэвслийн шинжээр зурагт үзүүлсэн ил шинж тэмдэг илэрвэл:

1. Өвчний шинж тэмдэг, сэжиг илэрсэн тухай өөрийн харьялах мал эмнэлгийн байгууллага болон малын эмчид албан ёсоор мэдэгдэх.
2. Дүүрэг, сумын засаг даргын захирамж, мал эмнэлгийн байгууллага, малын эмчийн шаардлагыг бүрэн биелүүлэх.
3. Малын эмчийн зааварчлагын дагуу өвчтэй мал байсан хашаа байрны бууц, баас, шээс, тэжээлийн үлдэгдлийг шатаах устгах буюу халдваргүйжүүлэх.
4. Эрүүл, өвчтэй малыг хооронд холих, малын эмчийн зөвшөөрөлгүйгээр шилжилт, хөдөлгөөн хийхгүй байх.

## МАЛЫН ЭМЧ ТА:

Анхны үзлэгээр зурагт үзүүлсэн ил шинж тэмдэг илэрвэл:

1. Цусны дээж, эмгэгт материалын эдийн дээжийг зааврын дагуу авч лабораторид хүргүүлнэ.
2. Бүх малд үзлэг хийж ил шинж тэмдэгтэй малыг тусгаарлана.
3. Хязгаарлалтын дэглэм тогтоох арга хэмжээ авч ус, бэлчээр нэгтэй айлуудын малд нэг бүрчлэн үзлэг хийнэ.
4. Өвчний онош тогтоогдох шийдвэр гарах хүртэл тогтоосон хязгаарлалтын бүсээс гарахыг хориглоно.

## МЭХ-ЫН БАЙЦААГЧ ТА:

1. Анхны шинж тэмдгийг үндэслэн хязгаарлалтын дэглэм тогтоох шийдвэр гаргуулна.
2. Хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоож хяналтандаа авч, эргүүл пост гаргана.
3. Захирамж болон бусад холбогдох хууль эрх зүйн актыг зөрчсөн этгээдэд зохих хариуцлага тооцох.

## ХОНЬ, ЯМААНД ИЛРЭХ ШИНЖ ТЭМДЭГ



# ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС ХАМТДАА СЭРГИЙЛЬЕ

## ИРГЭН ТА

Танай , галуу, тахиа, тэжээвэр шувуу тэжээл, усанд дурамжхан болж номойрч зурагт үзүүлсэн ил шинж тэмдэг илэрвэл:

1. Нэн даруй малын эмчид дуудлага өгнө.
2. Шинж тэмдэгтэй шувууг тусгаарлана.
3. Өөрийн шувууг өөр айлын шувуун сүрэгтэй нийлүүлэхгүй байх арга хэмжээ авна.

## МАЛЫН ЭМЧ ТА:

Анхны үзлэгээр зурагт үзүүлсэн ил шинж тэмдэг илэрвэл:

1. Цусны дээж, эмгэгт материалын эдийн дээжийг зааврын дагуу авч лабораторид хүргүүлнэ.
2. Бүх шувуунд үзлэг хийж ил шинж тэмдэгтэй шувууг тусгаарлана.
3. Хязгаарлалтын дэглэм тогтоох арга хэмжээ авна.
4. Өвчний онош тогтоогдож шийдвэр гарах хүртэл тогтоосон хязгаарлалтын бүсээс гарахыг хориглоно.

## МЭ-ИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ТА:

1. Хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэсвсгэрт хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоож хяналтандаа авч, эргүүл пост гаргана.
2. Анхны шинж тэмдгийг үндэслэн хязгаарлалтын дэглэм тогтоох шийдвэр гаргуулна.

## ТАХИАНД ИЛРЭХ ШИНЖ ТЭМДЭГ





## ЗЭРЛЭГ ШУВУУНД ИЛРЭХ ШИНЖ ТЭМДЭГ



# ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС ХАМТДАА СЭРГИЙЛЬЕ

**ХАЛДВАРЫН ЭХ УУРХАЙ**



Өвчтэй хүн, өвчтэй галуу, нугас тахиа зэрэг тэжээвэр болон зэрлэг шувууд

**ХАЛДВАР ДАМЖИХ ЗАМ**



Өвчилсөн шувууны сангас, шүлс эдгээр зүйлээр бохирлогдсон эд зүйлс

**Шувууны аж ахуй эрхлэгчдэд**

**ХҮНД ӨВЧИН ИЛРЭХ ШИНЖ ТЭМДЭГ**



Халуурах найтаах, хоолой, өвдөх, уушгины хатгалгаа, мөн булчин өвдөх,нүд үрэвсэх

ТЭЖЭЭВЭР ШУВУУДАА БУСАД МАЛ, АМЬТАН, ЗЭРЛЭГ ШУВУУТАЙ БҮҮ ХОЛИЛДУУЛ
ШУВУУТАЙ АЖИЛЛАСНЫ ДАРАА ГАРАА ТОГТМОЛ УГААЖ БАЙХ
ХЭРЭВ СЭЖИГТЭЙ БОЛОН ҮХСЭН ШУВУУ, ТҮҮНИЙ СЭГ ЗЭМТЭЙ ТААРАЛДВАЛ ХОЛБОГДОХ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГАД МЭДЭГДЭХ
ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРВЭЛ МАЛ ЭМНЭЛЭГТ ХАНДАХ



# ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС ХАМТДАА СЭРГИЙЛЬЕ

**Шувуу өвчлөх нь таны өрхийн санхүүд хохирол учирна**



**Эрүүл шувуу танд илүү их ашиг орлого өгнө**

**Таны шувууны аж ахуйд h1n5 өвчин оношлогдвол:**

1. Танай аж ахуйн мах,өндөг, болон бусад түүхий эд худалдаанд гарахад саадтай болно.
2. Түүхий эд, бүтээгдэхүүний үнэ унана.
3. Таны өрхий орлого буурна.
4. Таньд болон танай гэр бүлд үзүүлэх эрүүл мэнд, боловсролын болон бусад халамжийн үйлчилгээний зардал буурна




**Таны шувуу эрүүл бол:**

1. Танай шувууны ашиг шимийн гарц өндөр байна.
2. Бүтээгдэхүүний борлуулалтад саад үгүй байна.
3. Таны өрхий орлого нэмэгдэнэ.
4. Улсын эдийн засаг өсөж та хүртэх нийгмийн халамж нэмэгдэнэ





# МАЛ. АМЬТНЫ ГАЛЗУУ ӨВЧНИЙ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС ХАМТДАА СЭРГИЙЛЬЕ



**малын эмч та:**

Галзуугийн халдвар орсон /**галзуу нохой, чононд хазуулсан буюу галзуурсан мал, амьтан бүхий**/ суурийн бүх малд толгой дараалан үзлэг хийж шархтай мал, амьтдыг ялган 3 хоногийн дотор нядлуулах



Нядалсан болон өвчний улмаас үхсэн малын хүүр, сэг зэмийг халдваргүйжүүлэх бодис, бэлдмэлээр халдваргүйжүүлж /**булах эсвэл шатааж**/ устгана



Өвчтэй мал байсан хашаа саравч, байр, хэрэглэсэн ус, тэжээлийн онгоц, тоног хэрэгслийг /**малын эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн**/ халдваргүйжүүлэх бодис, бэлдмэлүүдийг ашиглан халдваргүйжүүлнэ






Өвчилсөн мал, амьтан
Бичил биетэн агаар дуслын болон шууд хавьтлын замаар тархана
Орчныг болон хөрсийг бохирдуулна
Мал, амьтанд, хүнд халдварлана,
Дамжин халдварлах замаар тархана
Mosquito Vector
Bird Amplifier Host

# МАЛ. АМЬТНЫ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ



**Малын шилжилт хөдөлгөөнийг бүрэн зогсооно.**

1. Мал эмнэлгийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр эрүүл нутгаас өвчин гарсан нутаг руу, өвчин гарсан нутгаас эрүүл нутаг руу шилжилт хөдөлгөөн хийхгүй

**Хорио цээрийн дэглэм хэрэгжүүлнэ.**

1. Мал эмнэлгийн болон эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэрийг бүрэн хэрэгжүүлнэ.



**Дархлаажуулалтад бүрэн хамруулна.**

1. Вакцинжуулалт хийхэд малаа бэлэн байлгана.
2. Вакцинжуулалт хийхэд малаа хашиж барьж өгнө



**Халдваргүйтгэлд бүрэн хамрагдана.**

1. МЭ байгууллагын зөвшөөрснөөр хөдөлгөөнд оролцоно
2. Малын хашаа, байр

# МАЛ. АМЬТНЫ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС ХАМТДАА СЭРГИЙЛЬЕ

